


БАТЛАВ
БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД


Х.БАДЕЛХАН

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД


Ц.НЯМДОРЖ

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 48-д “салбарын норматив баримт бичгийг боловсруулах, батлах, шинэчлэх, геодези, зураг зүйн улсын нэгдсэн санг бүрдүүлэх, тогтолцоог боловсронгуй болгох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох, иргэн, хуулийн этгээдийн геодези, зураг зүйн талаарх эрх, үүргийг нарийвчлан тусгах, геодези, зураг зүйн ажлын дараалал, магадлал хийх, жишиг үнэлгээг тогтмол шинэчлэх зохицуулалтыг тусгах зорилгоор Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах” гэж тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.80.2-т “...Геодези, зураг зүйн тухай хуулийн эрх зүйн шинэтгэлийг хийх” гэж заасан.

Геодези, зураг зүйн тухай хууль нь 1997 онд батлагдан түүнээс хойш 11 удаа 16 зүйл, 41 хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж, 2 хэсэг шинээр нэмсэн. Эдгээр нь бусад хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн 123 заалтын 30 хувьд өөрчлөлт орж, шинжлэх ухааны үндэслэл, тооцоотойгоор хийгддэг геодези, зураг зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээртэй холбогдсон бусад салбарын харилцааг зохицуулж буй зарим зүйл, хэсэг, заалтуудын уялдаа алдагдахад хүрсэн.

1.2.Практик шаардлага

1.Геодези, зураг зүйн салбар нь улсын хилийг тодотгон тогтоох, нутаг дэвсгэрийн хэмжээ, газрын гадаргын бодит байдал болон түүн дээрх бүхий л объектуудыг геодезийн өндөр нарийвчлал бүхий хэмжил зүйгээр орон зайн харилцан байршлаар зураглаж, байрлалд суурилсан орон зайн болон газрын зургийн тоон мэдээллээр газрын харилцаа, байгаль орчин, хөдөө аж ахуй, хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай зэрэг нийгэм, эдийн засгийн бүхий л салбаруудыг хангадаг, улс орны батлан хамгаалах аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Геодези, зураг зүйн тухай хуулиар нийтийн болон тусгай зориулалтын геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг ялган тодорхойлоогүйгээс геодезийн үйл ажиллагааг зөвхөн батлан хамгаалах зориулалттай мэтээр ойлгох явдал газар авч улмаар төрийн нууцын асуудал хөндөгдөж, геодезийн үйл

ажиллагаа, бүтээгдэхүүнийг нийтэд нь төрийн нууцад хавтгайруулан хамруулах явдал бий болж байна.

Иймд үйлдвэрлэл, үйл ажиллагааны зориулалт, түүний төрөл, ангиллыг ялгаж тусгах, тухайлбал, нийтийн буюу иргэний, тусгай буюу батлан хамгаалах зориулалтын гэх мэтээр геодези, зураг зүйн үйл ажиллагааг тодорхой тусгах шаардлагатай байна.

2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Геодези, зураг зүйн тухай хуульд геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйл ажиллагааны үр дүнд бий болсон төрөл бүрийн газрын зураг, тоон бүтээгдэхүүн нь олон зорилго, зориулалтаар ашиглаж болох суурь ажил, үйлчилгээ байдаг бөгөөд нэгдсэн нэг санд /төрийн архив/-д архивлахаар тусгасан байдаг. Гэвч тухайн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг төлөвлөх, захиалах, төсөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дараалал, хэрэгжүүлэх субъект тодорхойгүй, бусад салбарын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр бий болсон агаар, сансрын зураг, газрын зураг, тоон мэдээлэл геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд нэгтгэгдээгүй, мэдээллийн сан нэгдсэн биш байгаагаас салбар бүрт геодезийн ажил давхардаж хийгдэх, давхардсан хөрөнгө зарцуулах зэрэг асуудлууд гарсаар байна. Тухайлбал, нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тоон хэлбэрт оруулсан байхад Геологийн төв лаборатори, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд тус тусдаа тоон хэлбэрт оруулж өөрийн үйл ажиллагаандаа ашигласан. Өөрөөр хэлбэл, нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100000-ны масштабтай байр зүйн зургийг тоон хэлбэрт оруулахад улсын төсвөөс 3 удаа зардал гаргасан байна.

3. Газрын харилцаа, байгаль орчин, геологи, уул уурхайн салбар болон нийслэл хотод 1990 оноос хэрэгжүүлсэн гадаад, дотоод төсөл хөтөлбөрийн хүрээнд цуглуулсан газрын зураг, тоон мэдээлэлд тулгуурлан газар зүйн мэдээллийн системийг байгуулан ашиглаж эхэлсэн. Мөн эдгээр сангууд нь холбогдоогүй, мэдээлэл солилцдоггүйгээс ижил төрлийн ажил давхардан хийгдэх зэрэг хүндрэл гарч байна.

Геодези, газрын зураг, орон зайн өгөгдлийг нэгдсэн стандартаар бий болгох, байгууллага хооронд тэдгээрийг нэгдсэн сүлжээгээр /портал/ дамжуулах, ажлын уялдаа холбоо, мэдээллийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, мета өгөгдөл, мэдээний стандарт, үйл ажиллагааны нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг хуульд тусгах замаар шийдвэрлэх шаардлагатай байна.

4. Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, давтан мэргэшүүлэх үйл ажиллагаа нь тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрхлэх асуудалд хамаардаг. Уг үйл ажиллагааг барилгын салбарын мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, зэрэг олгох үйл ажиллагаатай зэрэгцүүлэн эрхэлж байгаа боловч тэр нь мэргэжлийн тусгай шаардлагыг хангасан, цогц сургалт, үйл ажиллагаа болж төдийлөн чадахгүй байгааг өөрчлөх шаардлагатай.

5. НҮБ-ын "Газар зүйн нэрийн шинжээчдийн бүлэг"-ээс зөвлөмж болгосны дагуу дэлхийн улс орнууд Засгийн газрын шийдвэрээр яам, агентлагуудын төлөөллөөс бүрдсэн "Газар зүйн нэрийн Үндэсний зөвлөл"-ийг байгуулан, батлагдсан газар зүйн нэрийг газрын зураг, атлас, албан хэрэг, бүх төрлийн ном, хэвлэл, мэдээлэл зэрэгт нэг мөр мөрдүүлэх, зөв бичиж хэвшүүлэх, галиглах, стандартчлах, түүхэн уламжлалт газар зүйн нэрийг сэргээн хамгаалах, нийтийн хүртээл болгох, орон нутгаас гаргасан газар зүйн нэрийн холбогдолтой бүхий л асуудлыг хэлэлцэн шийдвэр, зөвлөмжийг гаргадаг. Иймд тус зөвлөмжийн дагуу газар зүйн нэрийг өөрчлөх, шинээр олгох асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай.

6. Түүнчлэн гадаадын хуулийн этгээд Монгол Улсад геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах, бусад салбарт хийгдэж, ашиглаж байгаа геодезийн хэмжил, зураглалын ажил, бүтээгдэхүүнтэй холбоотой тэдгээрт төрийн хяналт тавих асуудлыг шинээр тусгах, геодези, зураг зүйн өгөгдөхүүн, газрын зураг ашиглан явуулж буй

үйлдвэрлэл, үйл ажиллагаанд эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх хөндлөнгийн /магадлал/ хяналт хийх нарийвчилсан зохицуулалт шаардлагатай.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь дараахь агуулгатай байна. Үүнд:

1.Геодези, зураг зүйн үйл ажиллагаа, бусад салбарт хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажил, үйлчилгээг улсын хэмжээнд нэгдсэн удирдлагаар хангах зохицуулалтыг тусгана.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг зураглахдаа урьд өмнө нь геодези, зураг зүйн ажил хийгдэж байсан эсэхийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн сангаас нягтлах, гүйцэтгэсэн геодези, зураг зүйн ажлын үр дүнг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд оруулдаг болох зохицуулалтыг тусгана.

Геодези, зураг зүйн ажлыг технологийн дарааллын дагуу гүйцэтгүүлэхэд заавал хийгдэх үйл ажиллагааны талаар эрх бүхий этгээдэд холбогдох журам батлах эрхийг олгох зохицуулалтыг тусгана.

2.Монгол Улсын хэмжээнд салбар бүрийн онцлогоос хамааруулан геодези, зураг зүйн асуудлыг төрөл, зориулалтаар нь ангилах /тухайлбал зориулалтаар нь нийтийн болон тусгай зориулалтын /бодлогын хэрэгжилтийг нэгдмэл байдлаар салбар хооронд уялдуулан зохион байгуулах, чиг үүргийг тодорхой болгох талаар нарийвчлан тусгана.

3.Улсын геодезийн сүлжээ байгуулах, бүх төрлийн зураглалын асуудлыг тусган, тэдгээрийн шинэчлэлт өөрчлөлтийг нэгдсэн бодлоготойгоор хийх, төрийн захиргааны байгууллагуудад хариуцуулах, хоорондын уялдааг хангах асуудлыг тусгана.

4.Нийтийн хэрэгцээнд зориулан гаргаж буй газрын зураг, атлас, сурах бичиг болон ном товхимол дээр гаргах улс, аймгийн хилийн шугам, газар нутаг, хот суурингийн нэр /газар зүйн нэр/ зэрэг зураг зүйн суурь мэдээ, мэдээллийг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд байгаа мэдээлэлд үндэслэн гүйцэтгэж, алдаагүй хэвлэдэг байх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг тусгана.

5.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Тухайн төрлийн аж ахуйн үйл ажиллагаанд хамаарах тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг тус тусын хуулиар зохицуулна.” гэж заасан. Иймээс тусгай геодези, зураг зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлт гаргасан этгээдэд тэдгээрийн техник, технологи, боловсон хүчний чадавхи, нөөцөд тохирсон ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгана.

6.Геодези, зураг зүйн ажлын үр дүнд магадлал хийх, геодези, зураг зүйн чиглэлээр мэргэшлийн зэрэг олгох сургалт зохион байгуулах, геодезийн хэмжлийн багаж баталгаажуулалтын зохицуулалтыг хуульд тусгана.

7.Геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын геодези, зураг зүйн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээ, эрх, үүргийг тодорхой болгох, газар зүйн нэрийн асуудал болон бусад төрийн захиргааны байгууллагуудын хүлээх эрх, үүргийг нарийвчлан тусгана.

8.Нэгдсэн портал сайтаар дамжуулан газрын зураг, орон зайн өгөгдлийг эрх бүхий этгээд болон иргэд, хуулийн этгээдийн хүртээл болгох, олон төрлийн хандалтаар үйлчлэх тогтолцоог буй болгох талаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагаварын талаар

Хуулийн төсөл батлагдсанаар нийтийн хэрэгцээний зориулалтаар том, дунд масштабын байр зүйн болон дэвсгэр зургийг төрөл бүрийн инженерийн байгууламжийн төлөвлөлтөд ашиглахаас гадна аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдэд газрын зураг, түүний тоон мэдээлэлд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдэж буй газрын зураг түүнд холбоотой бусад мэдээллүүдийг геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан хөмрөгт тогтмол нэгтгэж шинэчлэлтийг тогтмол хийж баяжуулснаар нийгмийн бүх салбарт бодит цаг хугацааны үнэн мэдээллээр хангах, газар зохион байгуулалт, зам тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, уул уурхай, байгаль орчин, хөдөө аж ахуй зэрэг дэд бүтцийн салбаруудад улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлын давхардсан хөрөнгө оруулалтыг арилгах, нийтийн хэрэгцээний газрын зураг, түүний тоон мэдээллээр үйлчлэх тогтолцоо бүрдэнэ.

Улсын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн шугам, газар зүйн нэртэй холбоотойгоор гарч байгаа газар нутгийн маргаантай асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

Иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөөр хийгдэж байгаа геодези, зураг зүйн ажлыг нэгдсэн санд төвлөрүүлэх эрх зүйн орчин бүрдсэнээр газар ашиглалтыг сайжруулах, төлөвлөлтийг зөв бодитой хийх, тэдний өмч хөрөнгийг хамгаалах, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эдийн засгийн хувьд дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар учруулахгүй бөгөөд тулгараад байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэж, геодези, зураг зүйн салбарын бүтээгдэхүүн хэрэглэгчдэд саадгүй хүрч улс орны хөгжилд эерэг нөлөө үзүүлэх болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт орох хуулийн талаар

Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Геодези, зураг зүйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.